

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 7352 дугаарт бүртгэв.

БОЛОВСРОЛЫН САЙД

2025 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/423

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газар (Н.Нарангэрэл), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, тушаалын хэрэгжилтийг ханган мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтныг боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн системд бүртгэхийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлуудад тус тус даалгасугай.

3.Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох явцыг боловсролын нэгдсэн мэдээллийн системд бүртгэх, системийн бэлэн байдлыг дэмжин ажиллахыг Цахим боловсролын газар (Т.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (У.Өлзийцэцэг)-т даалгасугай.

5.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/127 дугаар тушаалыг хүчингүй болгох ажлыг зохион байгуулахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газар /Н.Нарангэрэл/-т даалгасугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2025 оны 8 дугаар сарын 27-ны
өдрийн А/423 дугаар тушаалын хавсралт*

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН БАГШ, УДИРДАХ АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын багш, арга зүйч, сургалтын менежер, их, дээд сургуулийг багш мэргэжлээр төгссөн, багшлах эрхтэй сургалтын байгууллагад батлагдсан бүтэц, орон тооны нормативын дагуу үндсэн орон тоон дээр ажиллаж байгаа захирал (цаашид “багш, удирдах ажилтан гэх”)–д мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Мэргэшлийн зэрэг нь сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд холбогдох хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж үр дүнд хүрснийг баталгаажуулах, тэдний мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.3.Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа нь багш, удирдах ажилтны ур чадвар, манлайлал, ажлын үр дүнд суурилсан, үнэн бодитой, ил тод, нээлттэй, шударга, түншлэгч талын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

1.4.Энэхүү журмаар багш, удирдах ажилтны мэргэшлийн зэрэг нь ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, насан туршийн сургалтын байгууллагад нэгэн адил хүчин төгөлдөр, харилцан хүлээн зөвшөөрнө.

Тайлбар: “мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох” гэдэгт мэргэшлийн зэрэг шинээр олгох, бататгах (өмнө олгосон зэргийн шалгуурыг давтан хангаж байгааг баталгаажуулах), эсвэл ахиулах, хүчингүй болгох үйл ажиллагааг хамруулна.

Хоёр.Мэргэшлийн зэргийн шатлал, хүчинтэй хугацаа

2.1.Багш, удирдах ажилтны мэргэшлийн зэрэг нь “Заах аргач”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн шатлалтай байна.

2.2.Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жил байна.

2.3.Энэхүү журмын 4.13-т зааснаас бусад тохиолдолд мэргэшлийн зэргийг хугацаанаас өмнө олгохгүй.

2.4.”Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг 3 удаа, “Зөвлөх” мэргэшлийн

зэргийг 1 удаа бататгасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг сургалтын байгууллагад тухайн албан тушаалын үндсэн орон тоонд ажиллах хугацаанд байнгын хүчинтэйд тооцно.

Гурав.Мэргэшлийн зэрэг олгох шалгуур

3.1.Багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулахад дараах нийтлэг шалгуурыг баримтална:

3.1.1.багш мэргэжилтэй эсвэл багшлах эрхийн гэрчилгээтэй, сургалтын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;

3.1.2.тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, үндсэн орон тоонд ажилладаг байх;

3.1.3.сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

3.1.4.мэргэшлийн зэргийн шатлал ахиулахад өмнөх зэргийн хугацаа хүчинтэй байх;

3.1.5.мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах саналыг багш нарын хуралд оролцогчдын 80-аас доошгүй хувь нь дэмжсэн байх.

Дөрөв.Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1.Багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох эсэх шийдвэрийг энэхүү журмын 4.4-т заасан ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн дараах эрх бүхий албан тушаалтан гаргана:

4.1.1.“Заах аргач” мэргэшлийн зэргийг сургалтын байгууллагын захирал;

4.1.2.“Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг болон захиралд “Заах аргач” мэргэшлийн зэргийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга;

4.1.3.“Зөвлөх” мэргэшлийн зэргийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.

4.2.Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, ахиулах хүсэлтийг мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд багш, удирдах ажилтан томилох эрх бүхий албан тушаалтанд тухайн оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргана.

4.3.Багш, удирдах ажилтан дараах баримт бичгийг цахим хэлбэрээр боловсролын салбарын мэдээллийн системд энэхүү журмын 4.2-т заасан хугацаанд байршуулна:

4.3.1.мэргэшлийн зэрэг олгох, бататгах тухай хүсэлт;

4.3.2.мэргэшлийн зэрэгтэй тохиолдолд мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны албан ёсны шийдвэрийн хуулбар;

4.3.3.энэхүү журмын 3-т заасан шалгуурыг бүрэн хангасан болохыг нотлох баримт, мэдээлэл;

4.3.4.багш нарын хуралд оролцогчдын 80-аас доошгүй хувь дэмжсэнийг нотлох бичиг баримт.

4.4.Боловсролын салбарын мэдээллийн системд байршсан баримт бичгийг магадлан шалгах, үнэлэх, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг энэхүү журмын 4.1-т заасан эрх бүхий албан тушаалтан тус бүр томилон ажиллуулна:

4.4.1.Ажлын хэсэг 5 эсвэл 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд сургалтын байгууллагын ажлын хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.4-т заасан “ажилтны төлөөлөл” болон аймаг, нийслэлийн Боловсролын газрын холбогдох төлөөллийг оролцуулна;

4.4.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн эсэх тухай мэдэгдэл”-ийг мэргэшлийн зэрэг олгохтой холбогдох үйл ажиллагаа эхлэхийн өмнө батлагдсан маягтын дагуу гаргаж, ажлын хэсгийн даргад хүлээлгэн өгнө;

4.4.3.Ажлын хэсэг багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн шалгуур хангаж байгаа эсэхэд нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэн санал, дүгнэлт, зөвлөмжийг гаргана;

4.4.4.Мэргэшлийн зэрэг олгох шалгуур хангасан багш, удирдах ажилтны холбогдох мэдээллийг мэдээллийн системд баталгаажуулна;

4.4.5.Мэргэшлийн зэрэг олгох шалгуур хангасан эсэх нотлох баримтыг Боловсролын ерөнхий хуулийн 12.12, 35.5, 43.1-д заасан цахим систем, цахим мэдээллийн сангаас нягталж болно;

4.4.6.Шаардлагатай тохиолдолд мэргэшлийн зэрэг олгох шалгуурыг хангаж байгаа эсэхэд тухайн багш, удирдах ажилтны ажлын байранд очиж магадлан шалгах эсвэл цахим асуулга, сургалтын үйл ажиллагаанд ажиглалт болон баримт бичгийн шинжилгээ хийж болно.

4.5.”Заах аргач”, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгосныг гэрчилсэн албан ёсны баталгаа нь энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэр байна.

4.6.Сургалтын байгууллагын ажлын хэсэг багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн шалгуур хангасан эсэх дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хуралд нээлттэй танилцуулан санал, дүгнэлт, зөвлөмж, хурлын тэмдэглэл, тайланг захиралд тухайн оны 04 дүгээр сард багтаан танилцуулна.

4.7.Сургалтын байгууллагын захирал нь ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрийг тухайн оны 05 дугаар сарын эхний 7 хоногт багтаан гаргана:

4.7.1.шалгуур хангасан багш, удирдах ажилтанд “Заах аргач” мэргэшлийн зэрэг олгох, бататгах;

4.7.2.шалгуур хангасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн шалгуурыг магадлан шалгуулах, зэрэг олгох албан хүсэлтийг энэхүү журмын 4.1.2-т заасан байгууллагад гаргах.

4.8.“Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн шалгуурыг холбогдох ажлын хэсэг магадлан шалгах санал, дүгнэлт, зөвлөмж, тайланг энэхүү журмын 4.1.2-т заасан байгууллагын даргад тухайн оны 05 дугаар сард багтаан танилцуулна.

4.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрийг тухайн оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан гаргана:

4.9.1.шалгуур хангасан захиралд «Заах аргач» мэргэшлийн зэргийг болон багш, удирдах ажилтанд «Тэргүүлэх» мэргэшлийн зэргийг олгох, бататгах;

4.9.2.шалгуур хангасан багш, удирдах ажилтанд “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох албан хүсэлтийг холбогдох тайлан, дүгнэлтийн хамтаар энэхүү журмын 4.1.3-т заасан эрх бүхий албан тушаалтанд гаргах.

4.10.Энэхүү журмын 4.9.2-т ирүүлсэн тайлан, дүгнэлтийг нягтлан шалгуур хангасан багш, удирдах ажилтанд “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг тухайн оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

4.11.Зөвлөх мэргэшлийн зэргийн үнэмлэхийн загвар батлах, хэвлүүлэх, олгох маягтын дагуу мэдээллийн сан үүсгэх, үнэмлэхийг сургалтын байгууллагад түгээх болон бусад мэргэшлийн зэргийн мэдээллийн сан, хүчинтэй хугацаанд хяналт тавих зэрэг асуудлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

4.12.Мэргэшлийн зэрэг олгосон шийдвэрийн хувь болон шалгуур хангаагүй үндэслэл бүхий тайлбар, зөвлөмжийг цаасаар эсвэл цахимаар тухайн сургалтын байгууллагаар дамжуулан багш, удирдах ажилтанд хүргүүлнэ.

4.13.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.2-т заасныг үндэслэн олон улсын уралдаан, тэмцээн, төрөлжсөн олимпиадад багш болон суралцагч нь шагналт байр хүртсэн эсвэл амжилт гаргасан тохиолдолд багшид мэргэшлийн зэргийг хугацаанаас өмнө олгож болно.

4.14.Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн арга зүйн эхний шатны сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн багш, удирдах

ажилтанд “Заах аргач” мэргэшлийн зэргийн, ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд «Тэргүүлэх», «Зөвлөх» мэргэшлийн зэргийн 1 дэх шалгуурыг тус тус хангасанд тооцож болно.

4.1.15. Арга зүйч, сургалтын менежер, захирлын албан тушаалд ажиллах албан тушаалтан нь багшид тавигдах “Заах аргач” мэргэшлийн зэргийн шалгуурыг нэгэн адил хангасан тохиолдолд тухайн албан тушаалд тавигдах “Заах аргач” мэргэшлийн зэргийг олгоно.

4.16. Мэргэшлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн 80-аас дээш оноо авсан тохиолдолд багш, удирдах ажилтныг мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг хангасанд тооцно.

4.17. Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан нь ажлын хэсгийн дүгнэлт, саналыг баримт бичгийн бүрдэл хангуулахаар нэг удаа буцааж болох бөгөөд бусад тохиолдолд шалгуур хангасан багш, удирдах ажилтны материалыг буцаахыг хориглоно.

4.18. Мэргэшлийн зэрэг ахиулахаар хүсэлт гаргасан багш, удирдах ажилтан нь зэрэг ахиулах шалгуурыг хангаагүй тохиолдолд өмнө олгогдсон хүчин төгөлдөр мэргэшлийн зэргийг 1 жилээр сунгах шийдвэрийг тухайн мэргэшлийн зэргийг олгох эрх бүхий албан тушаалтан нь тухайн оны 06 дугаар сард багтаан гаргана.

4.19. Энэхүү журмын 4.18-д заасан үндэслэлээр мэргэшлийн зэргийг 1-ээс олон удаа сунгахгүй.

4.20. Багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд дараах шалгуурыг баримтална:

Багшид мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд баримтлах шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Заах аргач зэрэг	Тэргүүлэх зэрэг	Зөвлөх зэрэг	100 оноо
1	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	Боловсруулж баталгаажуулсан хөтөлбөрийн тоо, магадлан итгэмжлэл	Сургалтын байгууллагын түвшинд баталгаажуулсан 2-с доошгүй хөтөлбөр, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн оролцоо	Сургалтын байгууллагын түвшинд баталгаажуулсан 3-с доошгүй хөтөлбөр, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн багт ажилласан байдал	Үндэсний/салбарын түвшинд баталгаажуулсан 4-с дээш хөтөлбөр, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн багт ажилласан байдал	20
2	Сургалтын үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэл	Орчин үеийн сургалтын үнэлгээ, арга зүй нэвтрүүлэлт	Үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэлийг сургалтад туршсан, хариуцсан ангийн суралцагч, төгсөгчийн сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-с дээш хувиар өссөн байх, үнэлгээ тестийн сангийн баяжилт	Үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэлийг байгууллагын хэмжээнд түгээсэн байдал, хариуцсан ангийн суралцагч, төгсөгчийн сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-с дээш хувиар өссөн байх, үнэлгээ тестийн сангийн баяжилт	Үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэлийг салбарын хэмжээнд түгээсэн байдал, хариуцсан ангийн суралцагч, төгсөгчийн сурлагын чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 4-с дээш хувиар өссөн байх, үнэлгээ тестийн сангийн баяжилт	20

	Улсын болон олон улсын уралдаан тэмцээн, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө, шавьтайгаа 2-с доошгүй оролцсон байх, амжилт үзүүлсэн байх, сургалтын зүйн сургалт, семинар, зөвлөгөөн, өдөрлөг арга хэмжээний оролцооны тоо	Мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээн, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө, шавьтайгаа 2-с доошгүй оролцсон байх, амжилт үзүүлсэн байх, сургалтын байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээн, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө, шавьтайгаа 3-с доошгүй оролцсон байх, амжилт үзүүлсэн байх, сургалтын байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээн, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө, шавьтайгаа 4-с доошгүй оролцсон байх, амжилт үзүүлсэн байх, сургалтын байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	20	
3	Судалгаа, эрдэм шинжилгээ, багшийн хөгжил	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа, инновацын бүтээл	Сургалтын байгууллага, салбарын хэмжээнд хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан 1-с дээш эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	Аймаг, орон нутаг, бүсэд хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан 2-с дээш эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	20	
4	Хамтын ажиллагаа	Нийгмийн түншлэлийн хүрээнд хариуцсан анги, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Хариуцсан анги, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нийгмийн түншлэлийн холбогдох албан хаагч, бүсэд талуудтай хамтран хийсэн судалгаа, тайлан, үр дүн			20

Арга зүйчид (мэргэжлийн болон техникийн боловсролын, багшийн хөгжлийн) мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд баримтлах шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Тэргүүлэх зэрэг	Зөвлөх зэрэг	100 оноо
1	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	Боловсруулсан, баталгаажуулсан, шинэчилсэн, магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн тоо, холбогдох арга хэмжээ	Хариуцсан нэгжийн түвшинд бүрэн дунд боловсролын болон чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, агуулгад шинжилгээ хийсэн судалгаа, тайлан, сүүлийн 5 жилд хариуцсан нэгжийн түвшний нийт хөтөлбөр, төлөвлөгөөний 80-аас дээш хувийг баталгаажуулж хүчинтэй байх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцож ажилласан байдал, үр дүн	Хариуцсан нэгж, сургалтын боловсролын болон чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, агуулгад шинжилгээ хийсэн судалгаа, тайлан, сүүлийн 5 жилд хариуцсан нэгжийн түвшний нийт хөтөлбөр, төлөвлөгөөний 90-ээс дээш хувийг баталгаажуулж хүчинтэй байх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцож ажилласан байдал, түүний үр дүн	20
2	Сургалтын үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэл	Сургалтын хэлбэр, арга, технологид инновац нэвтрүүлсэн (e-learning, competency-based training, blended learning, dual гэх мэт) арга зүй	Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, орон нутгийн бусад сургалтын байгууллага, багш нарт зөвлөн тусалдаг байх, хариуцсан түвшний сургалтын нийт суралцагч, төгсөгчийн чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-с дээш хувиар өссөн байх	Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, бүс, орон нутгийн сургалтын байгууллагатай хамтран түгээн дэлгэрүүлдэг байх, хариуцсан түвшний сургалтын нийт суралцагч, төгсөгчийн чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 4-с дээш хувиар өссөн байх	20

3	Судалгаа, эрдэм шинжилгээ, багш, хөгжилд оруулсан хувь нэмэр, амжилт	Салбарын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа, инновацын бүтээл	Аймаг, орон нутаг, бүсэд салбарын болон мэргэжил, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ судалгааны тайлан 2-с дээш эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	Бүс, улсад салбарын болон мэргэжил, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ судалгааны тайлан 3-с доошгүй эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	20
	Хөгжилд оруулсан хувь нэмэр, амжилт	Багш нарт арга зүйн сургалт, зөвлөгөө зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр зөвлөгөө, чадавхажсан багшийн тоо	Хариуцсан нэгжийн багш нарыг улиралд 6-с доошгүй удаа арга зүйн нэгдсэн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулсан тоо, багш нарын 80-с дээш хувь чадавхажсан байх	Хариуцсан нэгжийн багш нарыг улиралд 6-с доошгүй удаа арга зүйн нэгдсэн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулсан тоо, багш нарын 90-с дээш хувь чадавхажсан байх	20
4	Хамтын ажиллагаа	Нийгмийн түншлэлийн хүрээнд суралцагч, төгсөгчийн үнэлгээг хамтран зохион байгуулах, арга зүйгээр хангах	Хариуцсан нэгж, түвшний сургалтын хөтөлбөр, үнэлгээ арга зүйн сургалтад хамрагдсан ААН, ажилтны тоо, сургалтын тоо, тайлан	Хариуцсан нэгж, байгууллага, бүх түвшний сургалтын хөтөлбөр, үнэлгээ арга зүйн сургалтад хамрагдсан ААН, ажилтны тоо, сургалтын тоо, тайлан	20

Сургалтын менежерт мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд баримтлах шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Тэргүүлэх зэрэг	Зөвлөх зэрэг	100 оноо
1	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	Хөтөлбөрийн шинжилгээ хийсэн байдал, шинэчлэл	Баталгаажуулсан нийт хөтөлбөр, төлөвлөгөөний тоо, ажил олгогчдын дүгнэлт, ногоон хөгжил, хүчирхийлэл, жендерийн бодлого төлөвлөлт, шинэ технологи, инновац, шатлан болон дүйцүүлэх агуулга, тэгш хамруулах, тохируулга хийсэн зэргээр агуулагд туссан нотлох хэсэг, баримт	Баталгаажуулсан нийт хөтөлбөр, төлөвлөгөөний тоо, ажил олгогчдын дүгнэлт, ногоон хөгжил, хүчирхийлэл, жендерийн бодлого төлөвлөлт, шинэ технологи, инновац, шатлан болон дүйцүүлэх агуулга, тэгш хамруулах, тохируулга хийсэн зэргээр агуулагд туссан нотлох хэсэг, баримт бичиг, шинээр хэрэгжүүлж буй олон улсын сургалтын хөтөлбөрийн үр дүн, тайлан	20
2	Чанарын баталгаа-жуулалт	Байгууллагын болон хөтөлбөрийн магадлан	Байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг удирдан ажилласан үр дүн, олон улсын магадлан итгэмжлэлийн арга зүйд суралцсан туршлага, магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа, гэрчилгээ	Байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг удирдан ажилласан үр дүн, олон улсын магадлан итгэмжлэлийн арга зүйн туршлагаа түгээсэн байдал, магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа, гэрчилгээ	15
		Сургалтын үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэл	Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, орон нутгийн бусад сургалтын байгууллага, багш нарт зөвлөн тусалдаг байх, нийт суралцагч, төгсөгчийн чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 3-с дээш хувийн өсөлт	Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, бүс, орон нутгийн сургалтын байгууллагатай хамтран түгээн дэлгэрүүлдэг байх, нийт суралцагч, төгсөгчийн чанар хөндлөнгийн үнэлгээгээр сүүлийн 5 жилийн дунджаар 4-с дээш хувийн өсөлт	20

3	Судалгаа, эрдэм шинжилгээ, инновац	Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын бүтээл	Аймаг, орон нутаг, бүсэд салбарын болон мэргэжил, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан 2-с дээш эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	Бүс, улсад салбарын болон мэргэжил, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан 2-с доошгүй эсвэл үндэсний хэмжээнд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан	15
		Багш нарт арга зүйн сургалт, зөвлөгөө зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр зөвлөгөө, чадавхажсан багшийн тоо	Багш, арга зүйчийг улиралд 6-с доошгүй удаа арга зүйн нэгдсэн зөвлөгөө өгөх эсвэл сургалт зохион байгуулсан тоо, багш нарын 80-с дээш хувь чадавхажсан байх	Багш, арга зүйчийг улиралд 6-с доошгүй удаа арга зүйн нэгдсэн зөвлөгөө өгөх эсвэл сургалт зохион байгуулсан тоо, багш нарын 90-с дээш хувь чадавхажсан байх	15
4	Байгууллагын хөгжилд оруулсан хувь нэмэр	Стратеги, эрх зүйн акт, бодлогын болон сургалтын баримт бичиг боловсруулах арга хэмжээ, ажлын хэсгийн оролцоо	Байгууллагын хөгжлийн стратеги, бодлогын болон сургалтын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт ажилласан байдал эсвэл удирдах байгууллагын ажлын хэсэгт ажиллаж үр гаргасан байдал		15

Захиралд мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд баримтлах шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Тэргүүлэх зэрэг	Зөвлөх зэрэг
1	Хөгжлийн бодлого, төлөвлөлт,	Санхүүгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, төсвийн сахилга бат	Санхүүгийн тайлан, аудитын зөрчилгүй байх, сургалтын орчны тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт, сүүлийн 5 жилийн дунджаар өөрийн орлогын хувь өссөн байх	Үндэсний болон олон улсын түвшний батламж, гэрчилгээ, үнэлгээний тайлан, магадлан итгэмжлэлийн хугацаа хүчинтэй байх
		Чанарын удирдлага, чанарын баталгаажуулалт нэвтрүүлсэн (ISO, TVET Quality Framework, магадлан итгэмжлэл ...)	Үндэсний хэмжээнд батламж, гэрчилгээ, үнэлгээний тайлан, магадлан итгэмжлэлийн хугацаа хүчинтэй байх	
		Нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг өргөжүүлсэн байдал	Гэрээ, санамж бичиг, идэвхтэй хамтран ажилладаг ААН-ийн тоо нэмэгдсэн байх, сургалтын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 3 жилд хувь өмнөх жилүүдээс өссөн хувь, хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 3 жилийн судалгааны харьцуулсан нэгдсэн тайлан	
			Рearson, хосмог гэх мэт сургалтын олон хэлбэрээр сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, бодит үр дүн, нийгмийн түншлэлийн үйл ажиллагааны гэрээ, санамж бичиг, идэвхтэй хамтран ажилладаг ААН-ийн тоо нэмэгдсэн байх, сургалтын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн хувь өмнөх жилүүдээс өссөн хувь, хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 3 жилийн судалгааны харьцуулсан нэгдсэн тайлан	

Байгууллага, багш, ажилтны хөгжил, сургалтын үйл ажиллагаа	Сургалтын үнэлгээ, арга зүй, технологийн шинэчлэл	Хөндлөнгийн үнэлгээний дүнгээр суралцагчдын төгсөлтийн үнэлгээ сүүлийн 5 жилийн дунджаар 3-с дээш хувиар өссөн байх, нотолгоотой байх	Хөндлөнгийн үнэлгээний дүнгээр суралцагчдын төгсөлтийн үнэлгээ сүүлийн 5 жилийн дунджаар 4-с дээш хувиар өссөн байх, нотолгоотой байх
2	Байгууллагын жилийн үйл ажиллагааны чанар, үр дүн	Сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээгээр сүүлийн 2 жил эрэмбэ III-с дээш үнэлэгдсэн байх	Сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээгээр сүүлийн 2 жил эрэмбэ II-с дээш үнэлэгдсэн байх
3	Дижитал шилжилт, мэдээллийн технологи ашиглалт	Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн дэмжлэг, урамшууллын ил тод, шуударга байдал	Хүний нөөцийн төлөвлөгөөгөөр нийт багш, ажилтны 80-с дээш хувь нь мэргэжлээ дээшлүүлсэн нотлох баримт, удирдлагын нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал
Шинэ санаачилга, инновац, технологи	Дижитал шилжилт, мэдээллийн технологи ашиглалт	IT шийдэл, программ, сургалтын байгууллагын веб хуудас, түүний хөгжүүлэлт, цахим хичээлийн технологи ашиглах боломжийг багш, ажилтан, суралцагчид бүрдүүлсэн байх	Хүний нөөцийн төлөвлөгөөгөөр нийт багш, ажилтны 90-с дээш хувь нь мэргэжлээ дээшлүүлсэн нотлох баримт, удирдлагын нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал

Тав.Мэргэшлийн зэргийн нэмэгдэл

5.1.Сургалтын байгууллага мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардлагатай зардлыг дараа оны төсвийн төсөлд тусган батлуулна.

5.2.Сургалтын байгууллага багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тогтоосон хувь хэмжээгээр тооцож олгоно.

5.3.Мэргэшлийн зэргийн шатлал ахиулсан багш, удирдах ажилтанд энэ журмын 5.2-т заасан нэмэгдлийг авах хүртэлх хугацаанд өмнөх мэргэшлийн зэргийн нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно.

5.4.Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод сургалтын байгууллагад үндсэн орон тоонд ажиллаж байгаа багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд нэмэгдлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

5.5.Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй сургалтын байгууллагад гэрээний дагуу ажиллаж байгаа гадаад багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгохгүй.

Зургаа.Мэргэшлийн зэргийг хэвээр хадгалах, хүчингүй болгох, сэргээх

6.1.Багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд хэвээр хадгална.

6.1.1.жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй тохиолдолд 3 хүртэл жил;

6.1.2.ажил олгогчийн шийдвэрээр мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын түвшний сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 хүртэл жил;

6.1.3.цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 хүртэл жил;

6.1.4.өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдлын улмаас ажил олгогчоос чөлөө авсан тохиолдолд 1 хүртэл жил;

6.1.5.Боловсролын ерөнхий хуулийн 17.1, 25.1, 27.1, 28.1-д заасан байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд дэвшиж, сэлгэн шилжиж ажилласан тохиолдолд тухайн мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл;

6.1.6.удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 2 хүртэлх жил өөр ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн хугацаанд.

6.2.Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг энэхүү журмын 6.1-д заасан хугацааг баримтлан багш, удирдах ажилтныг тухайн сургалтын байгууллагад үндсэн орон тоонд ажиллаж эхэлсэн хугацаанаас эхлэн үргэлжлүүлэн тооцно.

6.3.Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүйд тооцно:

6.3.1.мэргэшлийн зэргийн хугацаа дууссан, бататгаж сунгуулаагүй тохиолдолд;

6.3.2.мэргэшлийн зэргийн шалгуур хангасныг нотлох баримтыг хуурамч бүрдүүлсэн тохиолдолд;

6.3.3.төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн хорооны дүгнэлтээр тогтоогдсон;

6.3.4.багшлах эрхийг тодорхой хугацаагаар хасах, хязгаарлах шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргасан.

6.4.Мэргэшлийн зэрэг хүчингүй болгосон тухай мэдээллийг холбогдох байгууллага нь энэ журмын 7.1-д заасан бүртгэл, мэдээллийн санд ажлын 5 хоногийн дотор бүртгэнэ.

Долоо.Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх

7.1.Боловсролын цахим мэдээллийн системд сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сантай байна.

7.2.Мэргэшлийн зэргийн бүртгэлд мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтны мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллага, мэргэжил, албан тушаал, ажилласан жил, мэргэшлийн зэрэг олгосон, хүчингүй болгосон шийдвэр, огноо, бататгасан давтамж зэргээр ангилж, бүлэглэж харах боломжтой, ил тод нээлттэй байна.

7.3.Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн санг энэхүү журмын 4.1.1-т заасан сургалтын байгууллагын сургалтын менежер болон 4.1.2, 4.1.3-т заасан байгууллагын холбогдох нэгж тус тус бүртгэж, хөтөлнө.

7.4.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 7.3-т заасан мэдээллийн сангийн бүртгэлийг үүсгэх, хөтлөх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, дүн шинжилгээ хийнэ.

7.5.Багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн шийдвэрийг холбогдох хуульд заасны дагуу талууд архивын нэгж үүсгэн хадгална.

Найм.Бусад зүйл

8.1.Багш, удирдах ажилтнаас зэрэг олгох, хүчингүй болгохтой холбоотой гомдлыг тухайн мэргэшлийн зэргийг олгох эрх бүхий байгууллага, ажлын хэсэгт гаргана. Гомдлыг хүлээн авснаас хойш ажлын хэсэг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

8.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.4-т заасан ажилтны хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллага нь энэ журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, санал, зөвлөмж өгч болно.

8.3. “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагаанд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөлөл хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж болно.

8.4. Энэхүү журмын хэрэгжилтэд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутамд хяналт, шинжилгээ-үнэлгээг хийж ажиллана.

8.5. Энэхүү журмыг зөрчсөн ажлын хэсэг, багш, удирдах ажилтан, иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 17

Онон

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус сумын малчин, мал бүхий этгээдийн малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг 2026 оноос адуунд 1000, үхэрт 500, ямаанд 500, хонинд 300, тэмээнд 0 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Дэмбэрэлсайхан)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн бодлогын хороо (Х.Амарзаяа), Төсөв санхүү, дэд бүтцийн бодлогын хороо (Г.Гантуяа) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоолыг 2026 оны 01 сарын 01-ны өдрөөс хүчингүйд тооцсугай.

ДАРГА

А.УРТНАСАН

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авсан.*

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар А/179

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.4, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/423 дугаар тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ыг баталсан тул Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн “Журам батлах тухай” А/127 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.АУБАКИР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар А/1260

Даланзадгад сум

ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТ ХЭСЭГТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэхийг хориглох өдрийг шинэчлэн тогтоох тухай” А/1062 дугаар захирамжийн хавсралт хэсгийн 6 дахь заалт “Бүх шатны сонгуулийн өдөр” гэснийг хассугай.

2.Захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ч.Энхмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЭНХБАТ

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авсан.*

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 5 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар А/44

Эрдэнэт

ЗАХИРАМЖ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хууль, тогтоомж өөрчлөгдсөнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Цагийн хуваарь батлах тухай” А/19 дүгээр захирамжийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2.Захирамжийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Амгаланбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНБААТАР

